



## ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ” СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 07 өдөр

Дугаар A/02

Бор-Өндөр сум

Г Ажил, албан тушаалын жагсаалт, бүтэц  
орон тоо батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” 240 дугаар тогтоол, 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоол, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Орон тооны жишиг норматив батлах тухай” A/024/11 дугаар хамтарсан тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус сургуулийн 2025 оны ажил, албан тушаалын жагсаалт, бүтэц орон тоог хавсралт ёсоор баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан ажил, албан тушаалын жагсаалт, бүтэц орон тоонд багтаан төсвийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зарцуулж ажиллахыг нягтлан бодогч (Б.Анхчимэг)-д үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН УҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ч.АМАРЖАРГАЛ

